



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Дарви сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/126/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас:70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг:tsetseasurena@audit.gov.mn Аудитор: Н.Батзул Утас:70432545 Цахим хаяг: batzul.n@audit.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Төлбөрийн акт.....	10
3.2 Зөвлөмж	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ.....	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026-02-25 № 168
танай 2025-01-23 -ны № 2/29 -Т

ХОВД АЙМГИЙН ДАРВИ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.МӨНХЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарви сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн нийт зардлын дүн өмнөх оноос 597,6 сая төгрөгөөр буурсан нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал буурсан нь нөлөөлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Улсын тэргүүний Дарви сум нь 2025 оны ажлын үзүүлэлт, үр дүнгээр Ховд аймгийн 17 сумаас шилдэг сумаар шалгарсан байна.

8426050388

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>173,715,452.17</u>	<u>148,807,218.07</u>
33	АВЛАГА	73,764,572.17	33,027,338.07
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,440,913.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	70,323,659.17	25,577,338.07
335	Бусад авлага	-	7,450,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	7,450,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	99,950,880.00	115,779,880.00
354	Хангамжийн материал	51,616,880.00	67,445,880.00
35410	Бичиг хэргийн материал	1,687,500.00	805,500.00
35420	Аж ахуйн материал	2,989,000.00	16,200,000.00
35470	Бусад хангамжийн материал	46,940,380.00	50,440,380.00
35600	Мал амьтад	48,334,000.00	48,334,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,281,688,165.66</u>	<u>5,103,535,968.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,281,688,165.66	5,103,535,968.58
392	Биет хөрөнгө	4,251,003,165.84	5,073,368,468.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,668,611,768.30	5,802,099,219.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(991,228,078.28)	(1,389,835,586.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	782,208,108.30	817,158,108.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	(528,224,940.56)	(614,493,864.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	356,301,920.00	373,312,192.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(234,387,161.64)	(146,038,264.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	210,483,406.92	224,950,356.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(122,761,857.08)	(100,033,693.43)
39209	Зам, гүүрийн байгууламж	125,000,000.00	125,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(15,000,000.12)	(18,750,000.15)
393	Биет бус хөрөнгө	30,684,999.82	30,167,499.79
39301	Програм хангамж	4,395,000.00	4,395,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,710,000.18)	(4,227,500.21)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,455,403,617.83</u>	<u>5,252,343,186.65</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	<u>15,949,620.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	15,949,620.00
413	Өглөг	-	15,949,620.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,230,000.00
4136	Бусад өглөг	-	14,719,620.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	14,719,620.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,455,403,617.83</u>	<u>5,236,393,566.65</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,455,403,617.83	5,236,393,566.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	662,858,897.00	662,858,897.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,473,863,014.83	4,254,852,963.65
51210	Өмнөх үеийн үр дүн	3,473,863,014.83	3,473,863,014.83
51220	Тайлант үеийн үр дүн	-	780,989,948.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	318,681,706.00	318,681,706.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,455,403,617.83</u>	<u>5,252,343,186.65</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл (төгрөгөөр)
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,419,496,843.70	2,609,746,988.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,591,124,628.00	1,476,383,579.63
120	Нийтлэг татварын бус орлого	1,591,124,628.00	1,476,383,579.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,591,124,628.00	1,476,383,579.63
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,342,998.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,580,781,630.00	1,476,383,579.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,828,372,215.70	1,133,363,408.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,114,206,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,114,206,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	889,252,915.70	18,991,708.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	409,367,080.70	9,274,830.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	479,885,835.00	9,716,878.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	939,119,300.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	939,119,300.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	165,000.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	165,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,217,194,700.05	1,822,386,562.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,217,194,700.05	1,822,386,562.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,188,721,698.01	1,774,538,700.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	658,580,123.90	786,251,731.14
210101	Үндсэн цалин	320,325,763.90	407,506,745.00
210102	Нэмэгдэл	239,512,809.00	322,859,261.14
210104	Урамшуулал	50,909,689.00	35,689,725.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,831,862.00	20,196,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,732,399.41	98,129,912.86
210201	Тэтгэврийн даатгал	31,478,661.15	66,772,003.75
210202	Тэтгэмжийн даатгал	11,753,973.89	7,897,582.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,042,136.10	4,111,066.17
210204	Ажилгүйдлийн даатгал	5,656,438.31	3,863,693.81
210205	Эрүүл мэндийн даатгал	22,801,189.96	15,485,566.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,345,923.68	52,719,098.98
210301	Гэрэл, цахилгаан	12,085,833.68	19,526,530.98
210302	Түлш, халаалт	26,260,090.00	32,392,568.00
210303	Цэвэр, бохир ус	-	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,938,287.30	29,407,163.60
210401	Бичиг хэрэг	7,354,125.00	1,586,500.00
210402	Тээвэр, шатахуун	30,235,662.30	25,962,163.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,040,500.00	1,858,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	308,000.00	-

2105	Нормативд зардал	-	262,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	262,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	126,477.00	1,039,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,750.00	82,000.00
210604	Урсгал засвар	54,727.00	957,600.00
2107	Томилолт, зочны зардал	11,138,000.00	13,343,500.00
210702	Дотоод албан томилолт	11,138,000.00	13,343,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	302,862,509.28	185,810,048.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	301,380,661.28	184,816,090.90
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.00	515,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	122,135.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	34,000.00	34,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	591,606.00	180,700.00
210807	Газрын төлбөр	210,242.00	141,293.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,059,997,977.44	607,575,545.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	597,552,800.00	28,036,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	616,400.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	461,828,777.44	579,539,045.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,473,002.04	47,847,862.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,471,100.00	23,870,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,889,723.00	22,440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,581,377.00	1,430,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,001,902.04	23,977,862.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,001,902.04	23,977,862.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,202,302,143.65</u>	<u>787,360,425.82</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,202,302,143.65</u>	<u>787,360,425.82</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	(төгрөгөөр)
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	3,473,863,014.83	4,455,403,617.83
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	3,473,863,014.83	4,455,403,617.83
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	3,473,863,014.83	4,455,403,617.83
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	3,473,863,014.83	4,455,403,617.83
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	3,473,863,014.83	4,455,403,617.83
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	780,989,948.82	780,989,948.82
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	662,858,897.00	318,681,706.00	4,254,852,963.65	5,236,393,566.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,838,715,213.70</u>	<u>1,133,363,408.90</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,342,998.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	10,342,998.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,342,998.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,342,998.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,828,372,215.70	1,133,363,408.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,114,206,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,114,206,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	889,252,915.70	18,991,708.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	409,367,080.70	9,274,830.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	479,885,835.00	9,716,878.90
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	939,119,300.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	939,119,300.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	165,000.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	165,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,775,808,906.20</u>	<u>1,178,109,730.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,775,808,906.20	1,178,109,730.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,743,755,393.16	1,130,261,867.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	644,617,289.00	783,805,323.00
210101	Үндсэн цалин	333,087,380.00	367,108,759.00
210102	Нэмэгдэл	215,427,503.00	345,807,916.00
210104	Урамшуулал	48,230,096.00	36,872,648.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,872,310.00	34,016,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,056,800.00	96,979,000.00
210201	Тэтгэврийн даатгал	54,594,104.00	65,945,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,222,196.00	7,758,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,522,700.00	3,879,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,748,900.00	3,879,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,968,900.00	15,516,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,458,535.96	53,019,098.98
210301	Гэрэл, цахилгаан	10,026,597.96	19,526,530.98
210302	Түлш, халаалт	32,431,938.00	32,692,568.00
210303	Цэвэр, бохир ус	-	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,330,335.20	25,398,357.80
210401	Бичиг хэрэг	4,531,180.00	2,226,000.00
210402	Тээвэр, шатахуун	23,139,515.20	21,255,457.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,659,640.00	1,916,900.00
2105	Нормативт зардал	853,700.00	358,000.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553,700.00	358,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,773,700.00	1,203,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	367,600.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	287,400.00	246,000.00
210604	Урсгал засвар	2,118,700.00	957,600.00
2107	Томилолт, зочны зардал	11,138,000.00	12,113,500.00
210702	Дотоод албан томилолт	11,138,000.00	12,113,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	374,973,133.00	126,884,348.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	373,134,885.00	104,062,290.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	21,340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.00	515,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	122,135.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,000.00	34,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	948,006.00	668,800.00
210807	Газрын төлбөр	210,242.00	141,293.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	554,553,900.00	30,500,640.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	553,069,900.00	30,500,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,000.00	-
212	ТАТААС	3,524,611.00	-
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3,524,611.00	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3,524,611.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,528,902.04	47,847,862.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,527,000.00	23,870,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,782,000.00	22,440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,000.00	1,430,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,001,902.04	23,977,862.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,001,902.04	23,977,862.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	62,906,307.50	(44,746,321.10)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	62,906,307.50	(44,746,321.10)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,098,383,000.00	1,114,206,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,098,383,000.00	1,114,206,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,074,109,400.00	1,066,523,837.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	775,833,400.00	783,805,323.00
210101	Үндсэн цалин	404,126,600.00	367,108,759.00

210102	Нэмэгдэл	311,261,300.00	345,807,916.00
210104	Урамшуулал	26,429,500.00	36,872,648.00
210105	Гэрээт ажлын хөлс	34,016,000.00	34,016,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,979,000.00	96,979,000.00
210201	Тэтгэврийн даатгал	65,945,800.00	65,945,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,758,300.00	7,758,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,879,100.00	3,879,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,879,100.00	3,879,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,516,700.00	15,516,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,019,100.00	53,019,098.98
210301	Гэрэл, цахилгаан	19,287,400.00	19,526,530.98
210302	Түлш, халаалт	32,931,700.00	32,692,568.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	800,000.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	34,566,700.00	24,606,357.80
210401	Бичиг хэрэг	3,430,700.00	2,226,000.00
210402	Тээвэр, шатахуун	27,425,100.00	20,463,457.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,710,900.00	1,916,900.00
2105	Нормативт зардал	683,200.00	358,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	683,200.00	358,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,088,600.00	1,203,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	494,600.00	246,000.00
210604	Урсгал засвар	1,594,000.00	957,600.00
2107	Томилолт, зочны зардал	17,482,200.00	12,113,500.00
210702	Дотоод албан томилолт	17,482,200.00	12,113,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,412,000.00	73,619,458.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,210,900.00	72,137,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.00	515,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,000.00	122,135.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,000.00	34,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	765,800.00	668,800.00
210807	Газрын төлбөр	830,300.00	141,293.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,045,200.00	20,819,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,045,200.00	20,819,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,273,600.00	23,870,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,273,600.00	23,870,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,440,000.00	22,440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,833,600.00	1,430,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,098,383,000.00	1,114,206,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,098,383,000.00	1,114,206,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,098,383,000.00	1,114,206,700.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	89,315,368.07

21	УРСГАЛ ЗАРДАЛ	89,315,368.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,738,030.00
2104	Хангамж, бараа материалын зардал	792,000.00
210402	Тээвэр, шатахуун	792,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,264,890.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,264,890.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,681,140.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,681,140.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	25,577,338.07
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэг шилжүүлэг	25,577,338.07
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	89,315,368.07
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	89,315,368.07
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,274,830.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	80,040,538.07

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32,335.77 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад өвс, тэжээлийн тооцоотой холбоотой 7,450.0 мянган төгрөгийн өр, авлага тусгаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй 24,885.77 мянган төгрөгийн зөрчилд 2,306.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 22,579.67 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 24,885.77 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнийг хэтрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Илрүүлэлт: Сахилгын шийтгэлтэй алба хаагчдад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д зааснаар "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6-д "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-н 2.1,2.7 дахь заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Зардалтай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Зардлын зүйл анги зөрчин мэдээлэл технологийн үйлчилгээний зардлын ангиллаас 708,700₮-н бараа материал, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 98,000₮-н томилолт, түлш, халаалтын зардлаас 539,131₮-н бараа материал, цахилгааны төлбөр, шуудан, холбоо, интернэтийн зардлаас 1,697,800₮-н сургалт, шатахууны зардлыг, нийт 3,043,631₮-н зардлын зүйл анги зөрчин гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг бодитой төлөвлөх, төсвийн дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

3.2.2 Өр авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн засаг даргын тамгын газар, Онцгой комисстой өвс тэжээлтэй холбоотой өр авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь НББ-н тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Талуудын хооронд үүссэн өвс тэжээлийн тооцоог дахин тулган баталгаажуулалт хийж 2026 оны хагас жилийн тайлангаар үнэн зөв бүртгэж тайлагнах

3.2.3 Хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 11 мэдээлэл хоцорсон, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 4-р сараас бусад саруудад санхүүжилт мэдээлээгүй, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, дараа жилийн төсөв, зэрэг мэдээллүүдийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1-д заасан зарчмууд, 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн дагуу мэдээлэл мэдээллийг заасан хугацаанд, бүрэн гүйцэт, үнэн зөв мэдээлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөр, авлага бүртгээгүй	1	7,450.0	1	7,450.0			1	7,450.0	-	-
Дүн	1	7,450.0	1	7,450.0			1	7,450.0		

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Зардлын зүйл анги зөрчсөн	1	3,043.63	1	3,043.63						
2	Сахилгын шийтгэлтэй алба хаагчдад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон.	1	2,306.10					1	2,306.10		
3	Өвс тэжээлтэй холбоотой тооцоо нийлээгүй.	1	19,536.04	1	19,536.04						
	Нийт дүн	3	24,885.77	2	22,579.67			1	2,306.10		

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг бүрэн үнэн зөв мэдээлээгүй	1	0			0	1	-
ДҮН	1	0			0	1	0

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			